

НАРАН СУМЫН 2023 ОНЫ 7-Р САРЫН НЭГДСЭН ТАЙЛАН

2023.07.25

№ 08

Хонгор

ТӨРИЙН УДИРДЛАГЫН ЧИГЛЭЛЭЭР:

Нээлттэй хаалганы өдөрлөгийг зохион байгуулж, өдөрлөгт 52 иргэн хамрагдаж, мэргэжилтнүүд ажлын чиглэлээрээ хууль эрх зүйн мэдээлэл өгч, гарын авлага тарааж ажиллалаа. Төсөл хөтөлбөрт хамрагдсан иргэдийн бараа бүтээгдэхүүн сурталчлах үзэсгэлэн худалдаа зохион байгуулсан. 6 иргэн өөрсдийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнээр оролцсон.



Суманд нохой устгалын ажлыг БОХ-ын улсын байцаагч, Багийн Засаг дарга нар зохион байгуулж 25 нохой устгалаа.



УДИРДЛАГЫН БАРИМТ БИЧИГ:

Сумын агентлаг, төсөвт байгууллагын 2023 оны эхний хагас жилийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ үнэлгээ хийж тайланг системд шивж 9 төрлийн тайланг хугацаанд нь баталгаажуулж хүргүүллээ.

2023 оны 07-р сард албан хэрэг хөтлөлтийн явцад зохион байгуулалт, захирамжлалын баримт бичгийг бүрдүүлж, зааврын дагуу хөтөлж, дээд газраас ирж буй албан бичиг эрхийн актыг хүлээн авч, бүртгэн удирдах албан тушаалтанд танилцуулж, холбогдох албан тушаалтанд шийдвэрлүүлэхээр шилжүүлж, шийдвэрлэлтийн хугацаа, биелэлтэнд хяналт тавьж ажиллалаа.

-07-р сарын байдлаар дээд газраас нийт 30 албан бичиг ирснээс, хариутай бичиг 8 ирж, 3 албан бичгийн хариуг хугацаанд нь барагдуулж, хугацаа болоогүй 5 албан бичиг байна.

-Мөн 07 сарын байдлаар нийт 4 эрх зүйн баримт бичиг ирснээс Аймгийн Засаг даргын Захирамж – 3, Аймгийн Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын даргын тушаал 1 ирж хэрэгжиж байна.

-Хариутай бичгийн шийдвэрлэлтэд хяналт тавьж хугацаатай бичгийн шийдвэрлэлтийн мэдээ, тайланг гаргаж дотоод чатад тавьж мэдээлж ажиллаж байна.

Дотоодын ажлын талаар:

2023 оны 07-р сарын байдлаар;

- 1.Сумын Засаг даргын А-Захирамж - 16
- 2.Сумын Засаг даргын Б-Захирамж – 4
3. Албан даалгавар –
- 4.Засаг даргын албан бичиг -6
- 5.ЗДТГ-ын даргын А-Тушаал - 1
- 6.ЗДТГ-ын даргын Б-Тушаал - 3
- 7.ЗДТГ-ын даргын албан бичиг -2

Нийт 7 албан бичгийг имэйл, цахим шуудангаар болон сумын шуудангаар хүргүүлж ажилласан.

Аймгийн Эрүүл мэндийн газрын 2023 оны 07 дугаар сарын 04-ны өдрийн 384 дугаар зөвлөмжийг хүргүүлсэний дагуу сумын ЗДТГазраас 3-р Багийн засаг дарга, Хүнс, худалдаа үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн БОУБайцаагч Г.Цолмон, МЭТ-мэргэжилтэн Г.Сугар нарын бүрэлдэхүүнтэй худалдааны 5 ААН-д зөвлөмжийг хүргүүлсэн, мөн хүнсний бүтээгдэхүүний хадгалалтын хугацаанд хяналт хийж хадгалалтын горим зөрчсөн, түргэн гэмтэх хүнсний бүтээгдэхүүн төн хугацаа дууссан бараа бүтээгдэхүүнийг хураан авч хөрөнгө устгах комисс-т хүлээлгэн өгч устгал хийн ажиллаа.

Зөвлөмжийн дагуу ААН-д хугацаатай үүрэг чиглэл өгч, гарсан зөрчлийг арилгуулан зурагжуулан ажиллаа.



Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр:Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт хамрагдсан 4 иргэний 890000 төгрөгийн эргэн төлөлтийг төвлөрүүлсэн.

Шинэ ажлын байр -8, Ажил зуучлалаар -2 ejob программд бүртгэсэн.

2023 оны 06 дугаар сарын 26-ны өдөр ХЭХАХ мэргэжилтэн, Т.Болорчимэг, 1-р багийн Засаг дарга С.Сугар нар 5 өрхөд малжууах төслийн мал хүлээлцлээ.

1. 1-р багийн иргэн О.Нармандахад -91, Э.Батрагчаа-81, Т.Болдбаатар -72
П.Дэмбэрэлсумъяа -85, Б.Энхбатад 82 толгой малыг хүлээлцлээ.





07 сарын 20-нд Дарьганга суманд зохион байгуулагдсан өмнөд бүсийн “Ажил олгогч, бизнес эрхлэгчдийн “зөвлөгөөнд 13 хүний бүрэлдэхүүнтэй оролцож төсөл хөтөлбөрт хамрагдсан иргэдийг үзэсгэлэн худалдаанд оролцуулсан.



Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн чиглэлээр: ХАБЭА-н сарын аяны хүрээнд албан байгууллагуудад хяналт хийсэн үүний дагуу ерөнхий боловсролын сургуульд албан бичиг хүргүүлж ажиллаа.



Нийгмийн халамжийн чиглэлээр: Амьжиргааг дэмжих зөвлөлийн хурлыг 1 удаа хийж асаргаа сунгуулах 2, асран хамгаалагч солих-1 иргэний асуудлыг хэлэлцсэн.

Тэтгэвэр тэтгэмжийн олголт: 6 дугаар сарын 30-ны байдлаар

№	Тэтгэвэр, тэтгэмжийн төрөл	Хүний тоо	Мөнгөн дүн /мян.төг/
1	Нийгмийн халамжийн тэтгэвэр	178	50539974
2	Байнгын асаргаатай ахмад ,хүүхэд ХБИргэдийг асардаг	192	17629535
3	Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай иргэд	100	16817826
4	Ахмад настны тухай хуулийн дагуу	163	13270000
5	ХБ хүний эрхийн тухай хуулийн дагуу	54	1060645
6	Жирэмсэн эхийн тэтгэмж	86	3079241
7	Алдарт эхийн одонтой эхэд	144	18600000
8	Хүүхэд асарсны тэтгэмжинд	536	26211768

Татварын чиглэлээр:

Татвар төлөгчид татварын холбогдолтой цахим сургалт болон зөвөлгөөг сумын групп шэйр хийж 54 хүн мэдээлэл авсан. ААН-дэд онцгой албан татварын лац болон төлбөрийн баримт олголтын талаар хяналт тавьсан.

Одоогоор төвлөрөөд байгаа орлого

1. ҮХЭХАТ-150,000төг
2. МТТАТ-690500төг
3. Суутган-4-1310631төг
4. УТХ-19800төгрөг
5. ИҮХХБО-360,0төгрөг зэрэг орлогыг сумын төсөвт төвлөрүүлж ажилласан.

Нийгмийн даатгалын чиглэлээр:

1 ажил олгочийн 132000 мянган төгрөгийн шимтгэл оруулсан байна. Сайн дурын даатгалд 27 иргэн хамрагдаж 2031000 мянган төгрөг оруулсан. Эрүүл мэндийн даатгалд 3 иргэний 193400 мянган төгрөг оруулсан.

7 сарын 1 нд нийгмийн даатгалын хэлтэсээс 137,280,387.07 сая төгрөгийн санхүүжилт тэтгэврийн санд авсан байна.

2 сард нийт 288 иргэнд 168759.3 мянган төгрөгийн тэтгэвэр олгосон.

2 иргэнд тэтгэвэр шинээр тогтоосон.

1 иргэнд 3369118 мянган төгрөгийн жирэмсэн амаржсаны тэтгэмж олгосон.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Үндсэн ажилын хүрээнд:

Нийт үзлэг-162

Урьдчилан сэргийлэх-75

Амбулаторт-67

Идэвхитэй хяналт-20

Дуудлагаар гэрийн-0

Гэрийн эргэлт-14

Артерийн гипертензин эрт илрүүлэг-27

Чихрийн шижин эрт илрүүлэг-21

Жирэмсний хяналтанд байгаа-13

Шинээр хамрагдсан-2

Хөхний үзлэг-51

Эсийн шинжилгээ-5

Эмчилсэн эмэгтэйчүүд-2

Эмнэлэгт хэвтсэн-16

Түргэн тусламж-46

Дусал тариа-78

Судас тариа-115

Булчин тариа-11

Арьсан доорх тариа-2

Уян зүү-2

Боолт-10

Сорил тарилга-

Лаборатори /шинжилгээ/

Ковид шинжилгээ-5

Холестрин-3

ШЕШ-5

В,С-1

Дох, тэмбүү-2

Сахар-5

Алат асат-2

Альбумин-1

Үе мөч-3

Амилаза-3

Дархлаажуулалт

2сар-4

3сар-2

4сар-2

5сар-4

9сар-1 нийт 13 хүүхэд вакцинд хамрагдсан байна.

Баримт бичиг

Ирсэн бичиг-11

Явуулсан бичиг-9

Өргөдөл гомдол-3

Шийдвэрлэсэн -3

Шийдвэрлээгүй-0

Сургалт сурталчилгаа

1. Зөв хооллолт давсны хэрэглээгээр 6 хүнд сургалт орсон



2. Хүүхдийн хоолоор 3 эхэд сургалт хийсэн



3. Сумын баяр наадам, сунгаан үсэргээний үеэр унаач хүүхдийн аюулгүй байдал, наршилт осол гэмтлээс сэргийлэх 100ш зөвлөмж зөвлөгөө тараан ажилласан.



Улсын болон сумын баяр наадам аялал зугаалга эхэлж буйтай холбогдуулан гэрийн эргэлтээр 10 ахмад настан 14 бага насны хүүхдэд

- Наршилт
- Үеэр ус
- Осол гэмтэлээс сэргийлэх зөвлөгөө зөвлөмжийг тараан ажилласан.



4. Хэвтэн эмчлүүлсэн 2 хүүхдэд асаргаа сувилгаа хийсэн.



5. Хэвтэн эмчлүүлэгчийн ёс зүй дүрэм журмыг хэвтэн эмчлүүлсэн 14 иргэнд танилцуулсан.



СОЁЛ УРЛАГИЙН ЧИГЛЭЛЭЭР:

УДИРДЛАГЫН ЧИГЛЭЛЭЭР:

Соёлын төв 07 дугаар сард:

- Ирсэн бичиг – 1
- Явсан бичиг - 1
 - Хариутай бичиг – 1
 - Хугацаандаа явсан бичиг – 0
 - Хугацаа болоогүй бичиг – 1
 - Хугацаа хэтэрсэн бичиг – 0

НЭГ: ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР:

1.1. Цалин шинэчлэгдэн батлагдсантай холбоотой зохих тушаал, цалингийн шатлалыг гаргалаа.

1.2. 6-р сарын 20-оос эхлэн наадмын нээлтийн үйл ажиллагаанд оролцох хүүхэд, ардын авъяастануудыг оролцуулан бэлтгэл ажилдаа орсон бөгөөд үйл ажиллагаанд оролцсон хүүхэд, насанд хүрэгчидэд урамшуулал олголоо.

ХОЁР: ТӨСӨВ САНХҮҮГИЙН ЧИГЛЭЛЭЭР:

2.1. Төсвийн хүрээнд өр авлага үүсээгүй. Өөрийн үйл ажиллагааны орлого 330,000 төгрөг орсон.

ГУРАВ: НОМЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА:

3.1. Сар бүрийн эхний 7 хоногийн 5 дахь өдөр “Судар эгшиглэн” төслийн оролцогчдын уулзалт ярилцлага хийхээр төлөвлөсөний дагуу 07-р сарын 07-ний өдөр сумын “Хүүхдийн элч” Ж.Хүрэлчимэг, ЕБС-ийн номын санч Д.Чимгээ нартай хамтран зохион байгууллаа. Төсөлд оролцож ном уншиж, тэмдэглэл хөтөлж байгаа 5 том хүн, 18 сурагч хамрагдсан.

3.2. Номын сангийн фондод байгаа номыг цахимд оруулах ажлыг эхлүүллээ.

ДӨРӨВ: СОЁЛЫН ӨВИЙН ЧИГЛЭЛЭЭР:

4.1. Аймгийн ахмадын нумт харвааны аварга шалгаруулах тэмцээн 7-р сарын 1,2-ны өдрүүдэд болж өнгөрлөө. 17 багийн 130 гаруй ахмад харваачид цэц мэргэнээ сорьлоо.

ТАВ: ДУГУЙЛАНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА:

5.1. 7-р сарын 1-с эхлэн хөгжмийн дугуйланд нэмэлт элсэлт авч, үкүлэлэ 2, даралтат хөгжим 5, ёочин 3, нийт 10 хүүхэд хамрагдаж байна. Бүжгийн дугуйланд 6-р сарын 20-с эхлэн наадмын бэлтгэлд 24 хүүхэд хамрагдаж 6 бүжиг бүжиглэлээ.

ЗУРГАА: СОЁЛЫН ОЛОН ТАЛТ АРГА ХЭМЖЭЭ:

6.1. Ардын хувьсгалын 102 жил, Наран сум үүсэн байгуулагдсаны 68 жилийн ойн баяр наадмын нээлтийн үйл ажиллагааг 07-р сарын 10-ны өдөр 11 цагаас зохион

байгууллаа. Энэхүү арга хэмжээнд 7 ардын авъяастан, 29 хүүхэд оролцлоо. 1 цаг 15 минутын үйл ажиллагааг зохион байгуулсан.

6.2. Ардын авъяастан Бадарчийн Батаагийн анхны бие даасан “Удмын эгшиглэн” тоглолтыг 07-р сарын 10-ны өдрийн 19 цагаас зохион байгуулсан. Үүнд 5 ардын авъяастан оролцож, 65 үзэгч үзэж сонирхлоо.

6.3. 07-р сарын 10-ны 21 цагаас “Эх нутаг минь” хөтөлбөрт үдшийн цэнгүүнийг зохион байгуулахад 60 иргэн оролцлоо. 120,000 төгрөгийн орлого орсон.

6.4. 07-р сарын 12-ны үдэш 20 цагаас Наран сумын ЕБС-ийн 17-р төгсөлтийн хамт олонтой хамтран “Дурсамж” цэнгүүнийг зохион байгууллаа. Орлого 160,000 төгрөг орсон.

Зураг 4.1.





Зураг 5.1.



Зураг 6.1.





ТАЙЛАН НЭГТГЭСЭН О.ТУНГАЛАГ